



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2021 оны 10 сарын 19 өдөр

Дугаар 450

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө данснаас хасах зөвшөөрөл
олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь заалт, Засгийн газрын 2013 оны 38 дугаар тогтоолын 6 дугаар заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.2.1, 6.2.2, 6.2.4, 6.2.5, 6.4.3, 6.4.4, 6.4.6, 6.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн тусгай хамгаалалтын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, цаашид зориулалтын дагуу ашиглах боломжгүй нь Мэргэжлийн хяналтын улсын ахлах байцаагчийн 2021 оны 01-07-100/372 дугаар актаар тогтоогдсон, 63,293,707.85 (жаран гурван сая хоёр зуун ерэн гурван мянга долоон зуун долоон төгрөг наян таван мөнгө) төгрөгийн балансын үнэ, 60,856,529.31 (жаран сая найман зуун тавин зургаан мянга таван зуун хорин есөн төгрөг гучин нэгэн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын тэргүүн дэд дарга Б.Ганбат, Төрийн тусгай хамгаалалтын газрын дарга, хурандаа Л.Алтангэрэл нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасах, буулгах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Үл хөдлөх хөрөнгийн газар /чөлөөлөгдөх талбай/-ыг төрийн байгууллагын эзэмшилд хэвээр үлдээж, албан ажлын зориулалтаас өөрөөр ашиглахгүй байх, нөхөн сэргээх;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4.Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

133001360

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2021 оны дугаар сарын 1-ны өдрийн
 40 дугаар тогтоолын хавсралт

ТӨРИЙН ТУСГАЙ ХАМГААЛАЛТЫН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
 АКТАЛЖ ДАНСААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр	Үндсэн хөрөнгийн байршил	Ашиглалтад орсон, бүртгэсэн он (дахин үнэлгээгээр)	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Балансын нийт үнэ, бүртгэлийн үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Уурын зуух /дээд/	Хан-Уул дүүрэг, 11 дүгээр хороо	1960/2018	м2	301.84	26,019,765.15	24,550,135.22	1,469,629.93
2	Уурын зуух /доод/		1950/2018	м2	260.68	29,664,006.70	29,664,006.70	-
3	Хүлэмж		2006/2018	м2	240	537,120.00	537,120.00	-
4	Парник		2006/2018	м2	120	268,560.00	268,560.00	-
5	Хүлэмж		2010/2018	м2	120	1,196,500.00	228,951.39	967,548.61
6	Мөсөн гулгуур		2005/2018	м2	1078	5,607,756.00	5,607,756.00	-
	Нийт дүн					63,293,707.85	60,856,529.31	2,437,178.54